



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/63

Баян-Өндөр сум

Ариутгалын автоклав, дагалдах хэрэгсэл
хуваарилах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5 дах заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10 дах заалт, ЭМС-ын 2017 оны А/505 тоот “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар” тушаалын 4-р хавсралт, ЭМС-ын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/248 тоот “Тоног төхөөрөмж, орлогод авч хуваарилах тухай” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдал хангах төслийн хүрээнд нийлүүлэгдсэн эмнэлгийн хог хаягдлыг ариутгах автоклав, дагалдах хэрэгслийг эрүүл мэндийн байгууллагуудад олгох хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн эмнэлгийн хог хаягдлын автоклавын ашиглалт, техникийн үйлчилгээнд хяналт тавьж ажиллахыг Яаралтай гамшгийн үеийн тусламж үйлчилгээ, оношилгоо эмчилгээний технологи хариуцсан мэргэжилтэн /А.Батжаргал/-д, хавсралтын дагуу байгууллагуудад олгох, хүлээлцэх акт үйлдэх, анхан шатны бүртгэлийг бүрдүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газрын нярав /Б.Алтанзагас/ -т тус тус үүрэг болгосугай.

3. Хуваарийн дагуу олгосон эмнэлгийн хог хаягдлыг ариутгах автоклав, дагалдах хэрэгслийн ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэсийн ХШҮДАХариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Энхжаргалд/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 08 -р сарын
22 өдрийн А/Б тоот тушаалын хавсралт

ЭМНЭЛГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ АРИУТГАХ АВТОКЛАВ, ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ ОЛГОХ
ХУВААРЬ



№	НЭР ТӨРӨЛ	БОЭТ			ЖАРГАЛАНТ СЭМТ			БҮГД	
		Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ		
1	Эмнэлгийн хог хаягдлыг ариутгах автоклав 50л /CHW-LXB 50L-D БНХАУ/	1ш	4,580,300	4,580,300	1ш	4,580,300	4,580,300	9,160,600	
2	Автоклав тагны запас жийргэвч	2ш	84,000	168,000	2ш	84,000	168,000	336,000	
3	Өндөр температурт тэсвэртэй бээлий	4хос	28,000	112,000	4 хос	28,000	112,000	224,000	
4	Дижитал дэлгэцтэй электрон жин	1ш	169,000	169,000	1ш	169,000	169,000	338,000	
5	Ус нэрэгч	2ш	323,500	647,000	2ш	323,500	647,000	1,294,000	
6		Нийт			5,676,300	Нийт		5,676,300	11,352,600

Хуваарилсан: ЭБХЧАБЗХХМэргэжилтэн

Хянасан: ССНББХАжилтан

О.Анхбаяр

Н.Чулуун-Эрдэнэ